



## ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 10 сарын 11 өдөр

Дугаар 133

Мөрөн

Төлөөлөн удирдах зөвлөлд эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, "Шинэ Мөрөн Худалдааны төв" ОНӨХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.1 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Шинэ Мөрөн Худалдааны төв" ОНӨХК-ийн барилын 1,2 дугаар давхарт угсрах лангуу павлионы эскиз зургийг хавсралтаар баталсугай.
2. "Шинэ Мөрөн Худалдааны төв" ОНӨХК-ийн үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай павлион, лангуу хийх, зураг төсөв боловсруулах, угсралтын ажил гүйцэтгэхэд шаардлагатай 363,000,000 /гурван зуун жаран гурван сая/ төгрөгийг компанийд өр төлбөр үүсгэн худалдан авах ажиллагаа зохион байгуулж гэрээ байгуулахыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсүгэй.
3. Тухайн зардлыг компанийн ирээдүйн ашгаас тооцон 2018 оны эцэст эргэн төлөгдөх хугацаа, хувь хэмжээг тооцон бизнес төлөвлөгөөг боловсруулан ТҮЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхийг "Шинэ Мөрөн Худалдааны төв" ХК-ийн захирлын үүрэг түр орлон гүйцэтгэгч /Д.Эрдэнэболд/-д үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар /Б.Болд/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ТӨМӨРБААТАР

010559